210601	3.1.01.2.1.1.6.01 хэрэгсэл	Багаж, техник,	2,300,000.00	-
210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	22,479,500.00	20,290,300.00
2107	3.1.01.2.1.1.7 зардал	Томилолт, зочны	6,368,700.00	4,850,000.00
210702	3.1.01.2.1.1.7.02 томиллолт	Дотоод албан	6,368,700.00	4,850,000.00
2108	3.1.01.2.1.1.8 гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	Бусдаар	16,499,600.00	6,155,509.09
210801	3.1.01.2.1.1.8.01 гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	Бусдаар	7,285,500.00	-
210802	3.1.01.2.1.1.8.02 баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	Аудит,	546,000.00	-
210803	3.1.01.2.1.1.8.03 үйлчилгээ	Даатгалын	1,006,000.00	131,760.00
210804	3.1.01.2.1.1.8.04 хэрэгслийн татвар	Тээврийн	636,000.00	543,989.09
210805	3.1.01.2.1.1.8.05 хэрэгслийн оношлогоо	Тээврийн	286,000.00	-
210806	3.1.01.2.1.1.8.06 технологийн үйлчилгээ	Мэдээлэл,	6,160,100.00	5,000,000.00
210807	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	580,000.00	479,760.00
2109	3.1.01.2.1.1.9 үйлчилгээний бусад зардал	Бараа	76,667,200.00	64,680,400.00
210901	3.1.01.2.1.1.9.01 үйлчилгээний бусад зардал	Бараа	52,780,600.00	43,357,900.00
210902	3.1.01.2.1.1.9.02 үйлдвэрлэлийн дадлага хийх	Хичээл	23,886,600.00	21,322,500.00
213	3.1.01.2.1.4 ШИЛЖҮҮЛЭГ	УРСГАЛ	51,717,300.00	50,115,364.00
2132	3.1.01.2.1.4.2 шилжүүлэг	Бусад урсгал	51,717,300.00	50,115,364.00
213207	3.1.01.2.1.4.2.06 тэтгэмж	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	48,667,300.00	48,665,364.00
213209	3.1.01.2.1.4.2.08 тэтгэмж, шагнал урамшуулал	Нэг удаагийн	3,050,000.00	1,450,000.00
22	3.1.01.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	757,800,500.00	694,563,900.00
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	757,800,500.00	694,563,900.00
23	3.1.01.2.3	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	40,000,000.00	10,000,000.00
230001	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	40,000,000.00	10,000,000.00
8	3.1.01 НИЙТ ТЭНЦЭЛ	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН	977,885,100.00	- 96,457,867.57
9	3.1 САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	АЛДАГДЛЫГ	- 977,885,100.00	96,457,867.57

7	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 977,885,100.00	96,457,867.57
4	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	555,420,693.39
5	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	458,962,825.82
6	6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	68.00	59.00
61	6.1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.00	3.00
610001	6.1.01	Төсвийн байгууллага	3.00	3.00
62	6.2	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31.00	30.00
620001	6.2.01	Удирдах ажилтан	8.00	7.00
620002	6.2.02	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00
620003	6.2.03	Үйлчлэх ажилтан	4.00	3.00
620004	6.2.04	Гэрээт ажилтан	6.00	0.00

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	319,714,824.00
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	319,714,824.00
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	319,714,824.00
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	319,714,824.00
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	319,714,824.00
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	311,950,751.00
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,764,073.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	216,380,373.00
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	16,380,373.00
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,380,373.00
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,500.00
210104	1.1.1.2.1.1.1.4 Урамшуулал	514,500.00
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,168.00
210201	1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал	59,168.00
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	4,691,705.00
210401	1.1.1.2.1.1.4.1 Бичиг хэрэг	500,000.00
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	3,276,705.00
210406	1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	915,000.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,525,000.00
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,525,000.00
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	6,590,000.00
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	1,590,000.00

210902	1.1.1.2.1.1.9.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00
22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	200,000,000.00
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	200,000,000.00
223001	1.1.1.2.2.1.4 Бусад хөрөнгө	200,000,000.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	103,334,451.00
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	- 103,334,451.00
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 103,334,451.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэлд хамрагдсан байгууллагууд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Бусад

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Төрийн албаны тухай хуульд - 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр, 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нэгтгэл тайланд хамрагдсан байгууллагуудын мөрдөж байгаа мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 458.9 сая төгрөг болж, өмнөх оноос 96.5 сая төгрөгөөр буурсан байна .

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Төрийн сангийн харилцах	555.4	458.9	-96.5	82.6
Дүн	555.4	458.9	-96.5	82.6

Эх сурвалж: Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 458.9 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 294.1 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 72.1 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 92.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 227.0 сая, эцсийн үлдэгдэл 186.7 сая төгрөг болж, 40.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	7.8	5.0	-2.8
Ажиллагсадтай холбоотой авлага	0.0	0.0	0.0
Байгууллагаас авах авлага	56.0	56.0	0
Хувь хүмүүсээс авах авлага	21.0	20.6	-0.4
Зээлийн авлага	142.2	105.5	-36.7
Дүн	227.0	186.7	40.3

Эх сурвалж: Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл 256.7 сая төгрөг болж 29.7 сая төгрөгөөр буурсан нь хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлт хийгдсэнтэй холбоотой байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 136.4 сая, эцсийн үлдэгдэл 243.4 сая төгрөг болж, 107 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	3.2	3.7	0.5
Аж ахуйн материал	94.9	200.6	105.7
Сэлбэг хэрэгсэл	12.3	12.7	0.4
Бусад хангамжийн материал	2.2	2.2	0
Биологийн хөрөнгө		0.4	0.4
Мал амьтад	23.8	23.8	0.0
Дүн	136.4	243.4	107.0

Эх сурвалж: Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 243.4 сая төгрөг болж 107.0 сая төгрөгөөр өссөн нь сумын Засаг даргын тамгын газрын аж ахуйн материал өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,175.5 сая, эцсийн үлдэгдэл 2,881.4 сая төгрөг болж, 705.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	1,630.98	1,553.8	-77.18
Хуримтлагдсан элэгдэл	-634.75	-564.98	69.77
Авто-тээврийн хэрэгсэл	504.59	562.30	57.71
Хуримтлагдсан элэгдэл	-230.89	-208.53	22.36
Машин тоног төхөөрөмж(компьютер)	407.44	416.0	8.56
Хуримтлагдсан элэгдэл	-237.37	-222.81	14.56
Тавилга, аж ахуйн эд хогшил	63.34	101.11	37.77
Хуримтлагдсан элэгдэл	-36.14	-31.80	4.34
Зам гүүрийн байгууламж		99.40	99.40
Дуусаагүй барилга байгууламж		321.9	321.90
Бусад үндсэн хөрөнгө	167.40	283.94	116.54
Хуримтлагдсан элэгдэл	-92.43	-98.48	-6.05
Программ хангамж	3.13	8.125	5.00
Хуримтлагдсан элэгдэл	-3.13	-3.40	-0.27
Бусад биет бус хөрөнгө	633.40	664.80	31.40
Дүн	2,175.58	2,881.4	705.8

Эх сурвалж: Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,881.4 сая төгрөг болж 705.8 сая төгрөгөөр өссөн нь Засаг даргын тамгын газар төсвийн хөрөнгөөр 305.2 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, үнэ төлбөргүй хүлээн авсан 488.5 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч данс бүртгэлд тусгасантай холбоотой байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл 12.8 сая болж өглөг өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	12.1	2.5	-9.6
Байгууллагад төлөх өглөг	0.8	122.8	121.9
Бусад өглөг	0.0	2.5	2.5
Дүн	12.9	127.7	109.8

Өр төлбөр дансны үлдэгдэл 127.7 сая төгрөг болж 109.8 сая төгрөгөөр өссөн нь Засаг даргын тамгын газрын наадмын талбайн санхүүжилтийн өглөг үүссэнтэй холбоотой байна. Энэ нь оны эцэст хөрөнгө оруулалтын зардал хаагдсантай холбоотой байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний 3,081.6 сая, эцсийн үлдэгдэл 3,642.7 сая төгрөг болж, 561.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+/ бууралт /-/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	979.4	979.4	0.0	
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	1,771.0	2,388.0	616.9	
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	331.1	275.3	-55.8	
<u>Дүн</u>	3,081.6	3,642.7	561.1	

Эх сурвалж: Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3.642.7 сая төгрөг болж 561.1 сая төгрөгөөр өссөн нь тайлан үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 484.4 сая, татварын бус орлого 129.5 сая, нийт 613.9 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Аудитын илрүүлэлт:

Түргэн сумын Засаг даргын тамгын газар:

Аудитаар нийт 16.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 2.3 сая төгрөгийн алдааг залруулж, 11.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 1,153.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

✓ **Залруулсан алдаа**

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс авсан 2,300.0 мянган төгрөгийн цахилгааны нөөц үүсгэврийг үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.2 дахь заалт "Бүх

хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” болон Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэсэн.

✓ Төлбөрийн акт

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан архи, согтуурах ундааны 0.7 сая, аж ахуйн нэгжийн орлогын албан татварт гэж суутгасан 0.5 сая, нийт 1.2 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

✓ Албан шаардлага

Түргэн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын 100 жилийн ойн арга хэмжээ, уулзалт, бэлэг дурсгалын зүйлд 3.5 сая, Махардгийн овоо тахихад 3.2 сая, Засаг даргын тамгын газрын албан хаагчид Түргэн сумаас ОХУ-ын Абакан хот руу явсан тээврийн хөлс 5.0 сая, нийт 11.7 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

✓ Зөвлөмж

Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай хамааралгүй зардал гаргахгүй байж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг мөрдөн ажиллах зөвлөмж өгсөн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг 2,412.9 сая төгрөгөөр тооцож санхүүжүүлэх эх үүсвэрийг урьд оны үлдэгдлээс 134.2 сая, орон нутгийн орлогоос 423.2 сая, төсвийн дэмжлэгээр 1,079.2 сая, Орон нутгийн хөгжлийн сангаас 369.8 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн урд оны үлдэгдлээс 348.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 42.4 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 16,0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Түргэн сумын 2025 оны төсвийг сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн 03/01 дугаар тогтоолоор 2,689.1 сая төгрөгөөр баталж, 2025 оны 08 дүгээр сарын 14-ний өдрийн 06/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 276.2 сая төгрөгөөр бууруулж 2,412.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,412.9 сая төгрөгийн төсөв баталснаас сумын татварын болон татварын бус орлогоос 423.2 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 16.0 сая, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1,079.3 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 369.8 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн урд оны үлдэгдлээс 348.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлээс 42.4 сая, урд оны үлдэгдлээс 134.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр татварын орлого 484.4 сая, татварын бус орлого 72.1 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 57.3 сая, бусад орлого 103.3 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 361.8 сая, аймгаас авсан татаас тусламжийн орлого 1,079.3 сая, нийт 2,158.2 сая төгрөгийн эх үүсвэр тайлант онд бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,254.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Урд оны үлдэгдлээс зөрүү 96.5 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Түргэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны тодотгосон төсөв батлах тухай 2025 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн 06/01 дугаар тогтоолоор Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 423.2 сая төгрөгийн татварын орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 484.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 114.5 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 311.9 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7.8 сая, нийт 319.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 216.4 сая төгрөгийг зарцуулж, 103.3 сая төгрөгийн төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,446.9 сая төгрөгийн 1 хувь буюу 34.4 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 27.0 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөрчил илэрч албан шаардлага өгсөн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шилэн дансны цахим хуудаст 602,765.3 мянган төгрөгийн 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 508,806.2 мянган төгрөгийн 26 мэдээлэл байршуулаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж горим сорилыг баталгаажуулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/16 дугаар захирамжаар Түргэн сумын Засаг даргын Тамгын газрыг 17 орон тоотойгоор баталсан байна. Түргэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/01 тушаалаар Түргэн сумын Засаг даргын Тамгын газрын орон тоог 4 гэрээт ажилтнаар нэмэгдүүлэн баталсан байна. Тоймлон дурдвал, слесарь болон 1 сахиулыг төрийн үйлчилгээний албан тушаалын цалин хөлсөөр, 2 багийн сахиулыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулан ажиллуулсан байна. Дараагийн аудитаар бүтэц, орон тоог нягтлан шалгах нь зүйтэй гэж үзсэн

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 3 төсвийн байгууллага, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, 2 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 санг, төсвийн шууд захирагчийн 2 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	4	16.3	1	2.3	1	1.2	1	11.6	1	1.2
	Дүн	4	16.3	1	2.3	1	1.2	1	11.6	1	1.2

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,170.5 сая төгрөгийн 3 зөрчил илэрч аудитын явцад 70. сая төгрөгийн 1 алдааг залруулж 1,116.5 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өглөө.

5.1 Залруулга

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2025 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдаж авсан 70.0 сая төгрөгийн өвс, тэжээлийг бараа материалын дансанд бүртгэхгүй шууд авлага дансанд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.2 дахь заалт “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” болон Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулга хийлгэлээ.

1.2. Албан шаардлага:

Түргэн сумын Засаг дарга нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс Түргэн сумын Засаг даргын 2025 оны А/78 дугаар захирамжаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 06/01 дугаар

тогтоолоор баталсан “Дэлгэрмөрөн самбартай хөтөлд үдэлт, угталтын талбайн засвар” төсөл, арга хэмжээнд 5.0 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө”, 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.6 дахь заалтад “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална”, 13.3 дахь заалтад “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно” 13.3.1 дэх заалтад “Хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын 4.4 дэх хэсэгт “Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуулийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага өгсөн.

1.3. Албан шаардлага:

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шилэн дансны цахим хуудаст 602,765.3 мянган төгрөгийн 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 508,806.2 мянган төгрөгийн 26 мэдээлэл байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Алдаа зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Түргэн сумын ТТЗ	1	5.0			1	5.0						
Дүн	1	5.0			1	5.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Засаг дарга	1	1,111.5						1	1,111.5
Дүн	1	1,111.5						1	1,111.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Ч.МӨНХТОГТОХ/



2026 оны 03 сарын 25-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 02/64/А2070415
УВА-2026/004/НА-СТА-ТТЗ

Улаангом

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шилэн дансны цахим хуудаст 602,765.3 мянган төгрөгийн 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 508,806.2 мянган төгрөгийн 26 мэдээлэл байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийн таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн шаардах нь

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөн ажиллаж биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Түргэн сумын Засаг дарга Б.Гомбосүрэн, санхүү албаны дарга Б.Зулаад нарт хариуцуулав.


3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.МӨНХТОГТОХ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 01/63/А 2020 415
УВА-2026/004/НА-СТА-ТТЗ

Улаангом

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Түргэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түргэн сумын Засаг дарга нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс Түргэн сумын Засаг даргын 2025 оны А/78 дугаар захирамжаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 06/01 дугаар тогтоолоор баталсан “Дэлгэрмөрөн самбартай хөтөлд үдэлт, угталтын талбайн засвар” төсөл, арга хэмжээнд 5,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө”, 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.6 дахь заалтад “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална”, 13.3 дахь заалтад “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно” 13.3.1 дэх заалтад “Хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын 4.4 дэх хэсэгт “Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтад “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар

тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”, гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуулийн хүрээнд, зориулалтын дагуу зарцуулж биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- 2.
3. Цаашид алдаа таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Түргэн сумын Засаг дарга Б.Гомбосүрэн, санхүү албаны дарга Б.Зулаад нарт даалгав.
4. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.МӨНХТОГТОХ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ